

**НАЯНТ ВАНГИЙН “ДАНЖУУР”-ЫГ
АР МОНГОЛД ЗАЛСАН ТҮҮХЭН ХЭРГИЙН ТУХАЙ
(Жамъян гүн нарын Бээжин хотноо зорчсон “Замын тэмдэглэл”¹
ба холбоо бүхий архивын баримт бичгүүдийн жишээгээр)²**

Боржигин Чулуу

Товч агуулга. Монгол улсын Улсын номын санд хадгалж байгаа монгол модон барын “Данжуур” бол Цахар дахь Наянт вангийн харьяат нутгаас залж аваачсан гэдгийг эрдэмтэд сайн мэддэг. Гэвч түүний түүхэн бодит байдлын тухай нарийн тодорхой судлаагүй байсаар байна. Монгол улсын Улсын номын санд хадгалж байгаа Жамъян гүн нарын Бээжин хотноо зорчсон “Замын тэмдэглэл” ба зарим холбоо бүхий архивын баримтууд нь Наянт вангийн “Данжуур”-ыг Ар Монголд залсан түүхэн үйл хэргийг нарийсган судлах боломжийг бүрдүүлж байна. Тус өгүүлэлд Наянт вангийн “Данжуур”-ыг Ар Монголд хэн, хэзээ, хэрхэн залж аваачсан зэрэг асуудлуудад хариулт өгөхийг хичээв.

Түлхүүр үг: *Монгол Данжуур, Наянт ван, Ар Монгол*

Дайчин гүрний Тэнгэрийн Тэтгэсэн хааны үе буюу Нийтийн тооллын 1742 оноос 1749 оны хооронд “Данжуур”-ыг төвд хэлнээс монгол хэлэнд орчуулсан бөгөөд модон бард хэвлэсэн нь монгол ном бичгийн түүхэнд томоохон дурсгал бүхий үйл ажиллагаа болсон юм. Монгол модон барын “Данжуур” одоо дэлхий дээр гурван хувь хадгалагдаж бий. Тэр нь Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн номын сан, Өвөр Монголын номын сан, Монгол Улсын Үндэсний номын сан зэрэг гурван номын санд тус бүр нэг хувь хадгалагдаж байна.

Монгол улсад хадгалж байгаа “Данжуур” бол Цахар дахь Наянт вангийн харьяат нутгаас аваачсан хэмээн ном бичигт тэмдэглэдэг боловч түүний түүхэн бодит байдлыг төдий л нарийн судлаагүй байсан юм. Доор холбогдол бүхий архивын баримт материалд тулгуурлан Монгол улсын Үндэсний номын санд хадгалж байгаа “Данжуур”-ыг Наянт вангийн ордноос хэн, хэзээ, хэрхэн залж аваачсан тухай түүхийн нарийн байдлыг тодорхойлох болно.

¹ Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа “Судар бичгийн хүрээлэнгийн дараа сайд Жамъянгийн бие Хятад улсын Бээжин хотноо жич Эрдэнэзуу зэрэг газар очиход тэмдэглэсэн замын тэмдэглэлийн хамт” хэмээх нэр бүхий үдмэл дэвтрийг зааж буй. Энд “Замын тэмдэглэл” хэмээн товчлов. Даавуу гадар бүхий утсан үдмэл дэвтэр (нүүрийн тоо 57). Өмнөх хэсэг (13 нүүр) нь “Эрдэнэзуугийн зэрэг газар очиход тэмдэглэсэн замын тэмдэглэл” гэж, хойнох хэсэг (44 нүүр) нь “Судар бичгийн хүрээлэнгийн дарга сайд Жамъянгийн бие Бээжин хотноо одох тухай тэмдэглэсэн данс” хэмээн тус тус нэрлэж байна.

² БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний төсөл болох “Илийн голын урсгал дагуу орон дахь өвлдүүдийн хадгалж байгаа тод үсгийн дурсгалт бичгийн цуглуулга ба судлал” (төслийн дугаар: 18ZDA274)-ын хүрээнд бичсэн бүтээлийн нэг болно.

1. Жамъян гүн нар судар номын эрлээр Бээжин хотноо мордсон нь

20-р зууны эхэнд Монгол улсын Судар бичгийн хүрээлэн байгуулагдсаны дарга монгол ном судрын цуглуулгыг идэвхтэй хийж эхэлжээ. Тэд нар Монгол улсын дотоод дахь эл аймгуудаар явж ном судар цуглуулж байснаар барахгүй Бээжин зэрэг газраар тусгайлан ном судар цуглуулж явсан байна. Түүний нэгэн жишээнд Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн сайд Жамъян гүн нар олноо өргөгдсөний 13 он болон 14 онд тус бүр Бээжин хотод хоёр удаа судар номын эрлээр явсан түүхийг дурдаж болно. Монгол улсын Үндэсний номын санд хадгалж байгаа Жамъян гүн нарын “Замын тэмдэглэл”-д үндэслэвэл, Жамъян гүн нар нэгдүгээр удаа Олноо өргөгдсөний 13 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Хүрээ (одоогийн Улаанбаатар)-нээс гарч тус сарын 29-ний өдөр Бээжинд хүрч³ хагас жил гаруй болоод дараа жилийнх нь 4 сарын 10-ны өдөр Бээжингээс мордож 6 сарын шинийн 9-ний өдөр Нийслэл хүрээнд буцан харьжээ⁴. Энэхүү нэг жил шахмын хугацаанд Жамъян гүн нар Бээжин болон түүний эргэн тойрны зарим газар орноор монгол ном судар эрж хайж явсан байв. Жамъян гүн нар нэгдүгээр удаа Бээжин орсон “Замын тэмдэглэл”-д нэлээд олон хуучин ном судар худалдаж байсан пүүс болон “Ганжуур”, “Данжуур” зэрэг үнэт ховор ном судрын хадгалагдаж байсан байдлыг нарийн тэмдэглэсэн байдаг.

Жамъян гүн нар судар номын эрлээр хоёрдугаар удаа Бээжин орохоор мордсон нь Олноо өргөгдсөний 14 оны 10 сарын шинийн 3-ны өдрийн 2 цаг болно⁵. Даруй нэгдүгээр удаа яваад буцаж ирсний дараах 84 дахь өдөр юм. Энэ удаа Жамъян гүн нар Хүрээнээс мордож 8 өдөр яваад Жанчхүү орж, 13-ны өдөр Бээжинд хүрсэн байна⁶. Тэд Бээжинд 101 өдөр суугаад Олноо өргөгдсөний 15 дугаар оны цагаан сарын 26-ны оройн 8 цагт Жанчхүү зүг буцаж морджээ⁷. Энэхүү удаа буцах замдаа мөн нэгдүгээр удаатай адил Жанчхүүгээс мордон Цахарын нутгаар дамжиж хоёр сар гаруй яваад 4 сарын 12-ны өдөр хүрээд хүрч⁸, тус удаагийн аялал дуусдаг. Жамъян гүн нар энэхүү хоёрдугаар удаа Бээжингээс Цахарын нутгаар дамжин буцах замдаа Наянт вангийн харьяат нутгаар дайрч “Данжуур”-ыг Ар Монголд залж аваачсан юм.

Хоёрдугаар удаагийн Бээжин орсон “Замын тэмдэглэл”-д Жамъян гүн нар Наянт вангийн ордонд хүрсэн цагийг Олноо өргөгдсөний 15 дугаар оны 2 сарын 6-ны өдөр хэмээн тэмдэглэж буй⁹. Наянт вангийн ордонд хүрсэн тухай өдрийн тэмдэглэлд “2 сарын 6-нд 20 газар явж Улаан худаг хэмээх газар үдлээд 20 газар явж Сайн цэцэн чин ван Наянтын ордны газар буув”¹⁰ гэж буй. Гэвч Наянт вангийн ордонд хүрсний дараа болсон үйл явдлыг ерөөс дурдсангүй. Харин дараа өдөр нь буюу 7-ны өдөр “60 газар явж Завсар хэмээх газар монгол айлд хоноглов”¹¹ гэж, “8-ны өдөр 50 газар явж Цахарын Өөлд гүнгийн нутагт хоёр хонож”¹² гэж, “10-ны өдөр Цахар Хөвөөт шар хошууны Аюуш хэмээх айлд буув”¹³ гэж тус тус тэмдэглэж бий. Үүнээс үзэхэд Жамъян гүн нар Наянт вангийн ордонд зөвхөн нэг өнжөөд гарсан байна. “Данжуур” номыг Наянт вангийн харьяат нутаг дахь Шашныг бадруулагч сүмд тахиж байсан болохоор Жамъян гүн нар Наянт вангийн ордонд нэг их удалгүй үргэлжлэн хойш аялжээ.

³ “Судар бичгийн хүрээлэнгийн дарга сайд Жамъянгийн бие Хятад улсын Бээжин хотноо жич Эрдэнэзуугийн зэрэг газар очиход тэмдэглэсэн замын тэмдэглэлийн хамт”. Монгол улсын Үндэсний номын сангийн хадгаламж (хадгаламжийн дугаар: 2220/96) х.18.

⁴ Мөн тэнд. х.35.

⁵ Мөн тэнд. х.49.

⁶ Мөн тэнд. х.50.

⁷ Мөн тэнд. х.51.

⁸ Мөн тэнд. х.56.

⁹ Мөн тэнд. х.53.

¹⁰ Мөн тэнд. х.53.

¹¹ Мөн тэнд. х.53.

¹² Мөн тэнд. х.53.

¹³ Мөн тэнд. х.53.

2. “Данжуур”-ыг залах явцад тохиолдсон асуудал ба Бээжинд хүн томилсны учир

Жамъян гүн нар Наянт вангийн ордноос 7-ны өдөр мордож гарсны дараа 12-ны өдөр болтол таван өдөр туж зам хөөжээ. “Замын тэмдэглэл”-ийн 12-ны өдрийн тэмдэглэлд “12-нд На вангаас судар тушааж өгөхөөр гаргасан түшмэл Хишигдалайг Бээжин оруулахаар явуулав”¹⁴ гэх агуулга гэнэт тохиолдоно. Яг энэхүү зурвас агуулгын өмнө мөрт “На вангийн хошууны хэдэн хүн Данжуурыг өгөхгүй хэмээсэн учирт”¹⁵ гэх мөрийн завсар сүүлд нь нөхөж бичсэн нэг мөр үсэг бий. Энэхүү хоёр мөр үсгийн агуулгаас үзвэл 12-ны өдөр Жамъян гүн нар “Данжуур”-ыг авч явах гэсэнд Наянт вангийн нутгийн хэдэн хүмүүс өгч явуулахгүй гэсэн болохоор Хишигдалай гэгч хүнийг Бээжинд томилж явуулсан юм байна. Тэмдэглэлийг бичсэн хүн Хишигдалайг Бээжинд томилж явуулахын шалтгааныг ойлгохгүйгээс болгоомжлон өмнө талд нь “хэдэн хүн Данжуурыг өгч явуулахгүй” гэсэн учрыг нөхөж бичсэн байж болох юм. Нөхөж бичсэн тэрхүү хэсгийн гарын тиг болон үзгийн байдлаас үзвэл тухайн цагт нь бичсэн бололтой.

Хишигдалай гэгч хүний тухай тодорхойлох хэрэгтэй байна. Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд тавиаатай Жамъян гүн нарын “Данжуур”-ыг залсан хөшөө чулууны бичгийн хоёрдугаар зүйлд “энэ Данжуур ном болбоос бүрнээ нийт хоёр зуун хорин зургаан ботийг дагалт Хишигдалай бүрнээ жонон ван нар дутагдалгүй тушаан өгвэй”¹⁶ хэмээн тэмдэглэж буй. Өөрөөр хэлбэл Хишигдалай гэгч хүн Наянт вангийн томилолтоор Жамъян гүн нарт Данжуурыг гардан тушааж өгсөн хүн болно. Энэхүү гэрээ бичигт тэмдэглэгдсэн Хишигдалай гэгч хүн яг сайхан өгүүлэн буй “Замын тэмдэглэл”-ийн агуулгатай нийцэж байна.

Бас нэгэн бодууштай зүйл гэвэл, “На вангийн хошууны хэдэн хүн ‘Данжуур’-ыг өгөхгүй хэмээсэнд Бээжинд хүн томилохын учир нь юу? Жамъян гүн нар Цахар дахь Наянт вангийн ордонд хүрээд Наянт вантай уулзсан уу?” Эдгээр асуудал их сонирхолтой байна. “Замын тэмдэглэл” хэдийгээр цаг хугацааны талаар маш нарийн тэмдэглэж байгаа боловч, тохиолдсон хэрэг учрын тухай төдий л нарийн тэмдэглэсэнгүй болохоор үүний цаана ямар асуудал буйг ойлгоход бэрхтэй юм. Үүний учрыг Наянт вангийн намтар түүхтэй холбогдуулан үзвэл ойлгомжтой болно.

Наянт ван (1867-1938) бол Дайчин гүрний гадаад засаг хошууны сайн ноён хан, хошой чин ван бөгөөд гүрний эфү Цэрэнгийн хойчис юм. Цэрэн Энх-Амгалан хааны үед удаа дараа гавьяа байгуулж өндөр зэрэг хэргэм хүртсэн ба Цахар найман хошууны нутагт өөрийн эзэмшлийн бэлчээр нутагтай байжээ. Дайчин гүрний эхээр ноёрхогчид Цахарт их хэмжээний бэлчээрийг эзэмдэн, хаан угсааныхан буюу гавьяа байгуулсан язгууртнуудад бэлчээр болгон шагнаж байсан болохоор Сайн ноён хан Цэрэн Цахарт эзэмшил нутаг хүртсэн юм. 1874 онд Наянт Халхын засаг хошой сэцэн чин вангийн сууриныг залгамжилжээ. Наянт вангийн ордон Бээжинд байсан бөгөөд тухайн үеийн гадаад засаг хошууны ван нараас зөвхөн Наянт ван Бээжинд ордонтой байсан юм. Тэрчлэн сайн ноён хан Цэрэнгийн үед соёрхсон Цахар дахь эзэмшил нутаг нь Наянт вангийн үе хүртэл мөн өмчилсөөр ирсэн байжээ. Өгүүлэн буй Цахар дахь Наянт вангийн ордон гэдэг бол яг энэхүү эзэмшил нутаг дахь ордныг нь зааж байна. Энэхүү түүхэн бодит байдлыг “Замын тэмдэглэл” дэх агуулгатай зүйчлэн үзвэл, тухайн үед Наянт ван Бээжин дэх ордондоо байсан бөгөөд Жамъян гүн нар Бээжинд Наянт вантай “Данжуур” залах учрыг хэлэлцэн тогтоод дараа нь сая Цахар дахь харьяат нутагт нь ирсэн байжээ. Тийнхүү Наянт вангийн харьяаны нутгийн хүмүүс “Данжуур”-ыг өгч явуулахгүй болсонд Жамъян гүн нар Хишигдалай (Наянт ван “Данжуур”-ыг тушааж өгөхөөр

¹⁴ Мөн тэнд. х.53.

¹⁵ Мөн тэнд. х.53.

¹⁶ Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд буй “Данжуур”-ыг залсан хөшөө чулууны бичиг. Энд уг гэрээ бичгийг олж үзсэнгүй болохоор хөшөө чулуун дахь сийлбэрийн агуулгыг ашиглав. Хөшөөний нүүр талын 8 дугаар мөр.

тусгай томилсон хүн)-г Бээжинд очуулж Наянт вангаас зөвшөөрлийн бичиг мэтийн зүйлийг авчруулах гэсэн байх ёстой. Хишигдалайн Бээжинд явсны учир нь ийм юм. Нөгөө нэг асуудал нь Жамъян гүн нар Цахар дахь Наянт вангийн ордноор дайрсан боловч тухайн үед Наянт ван Цахар дахь ордондоо байсангүй бололтой.

3. “Данжуур”-ыг залах гэрээ бичиг ба түүний тогтсон цаг

“Замын тэмдэглэл”-д үндэслэвэл, Жамъян гүн нар Олноо өргөгдсөний 15 дугаар оны 2 сарын 6-ны өдөр Цахар дахь Наянт вангийн ордонд хүрсэн байв. Гэвч Цахар дахь Наянт вангийн ордонд “Данжуур”-ыг залах тухай хэргийг зөвлөсөн биш, харин үүнээс өмнө Жамъян гүн нар Бээжинд Наянт вантай уулзаж “Данжуур”-ыг залах гэрээ бичгийг нэгэнт тогтчихсон байжээ. Үүнийг доорх мэт хоёр зүйлийн баримтаар тодорхойлж болно.

Баримт нэг. Монгол улсын эрдэмтэн Э.Хүрэлбаатарын хувийн архивт хадгалагдаж байгаа “Данжуур”-ыг залахад холбогдох нэгэн захидал бий. Түүнийг сийрүүлбэл доорх мэт:

Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмт гишүүн түшмэд Танаа амгаланг эрж сонсгох ану, Данжуур залах тухайн гэрээ бичигт гар тавьж, жич талархах зүйлийг уг хэлэлцсэн ёсоор нэгэнт гүйцэтгэсэн бөгөөд, одоо уг судрыг тушааж өгөх хүнийг томилон гаргах ба бас ч өөр зүйлийн түр хүлээх хэрэг буй тул Жамъян миний бие энэ гурван сарын аравдын хурд Бээжингээс гараад Жанчхүү дайран авдар юмыг тээлгэн Данжуур залж буй Сүмийн газар очиж хүлээн аваад тэндээс тэмээнд ачуулан Замын-Үүдэд буухаар тогтсон ба Замын-Үүднээ хүрмэгц дарм утсаар мэдэгдэхийг сонсгож мунхаг Ширнэндамдин Жамъян нар ёслов¹⁷.

Энэ захидал бол Жамъян гүн нар Бээжингээс Монгол улсын Судар бичгийн хүрээлэнд илгээсэн хариу мэдэгдэх захидал болох нь тодорхой байна. Тухайлбал, “Данжуур”-ыг залах гэрээ бичгийг нэгэнт тогтсон бөгөөд хэзээ, хаанаас яаж авч явах тухай төлөвлөгөөг хариу мэдэгдэж бас Монгол улсын хил болох Замын-Үүдэд хүрмэгц утсаар ярих тухайгаа мэдэгдэж буй. Захидалд “Гэрээ бичигт гар тавьж” гэх үг буйгаас үзвэл Жамъян гүн нар Цахарт хүрч ирэхээс өмнө Наянт вантай Бээжинд нэгэнт “Данжуур” залах учрыг хэлэлцэн тогтоод гэрээ бичиг байгуулчихсан байжээ.

Баримт хоёр. Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд тавиаастай Жамъян гүн нарын “Данжуур”-ыг залсан хөшөө чулуунд сийрүүлсэн “Гэрээ бичиг”-ийн төгсгөлд “Монгол улсын арван дөрөвдүгээр он арван сарын хорин найман¹⁸ хэмээн уг гэрээг тогтсон цагийг тэмдэглэж буй. Энэхүү цаг хугацаагаар бодвол Жамъян гүн нар Цахар дахь Наянт вангийн ордонд хүрч ирэх (Олноо өргөгдсөний 15 дугаар оны 2 сарын 6-ны өдөр)-ээс гурван сар гаруйн өмнө нэгэнт гэрээ бичгийг тогтчихсон байжээ.

Тухайлбал, Жамъян гүн нар Цахарт ирэхээс өмнө Бээжинд Наянт вантай уулзан “Данжуур” номыг Ар Монголд залах хэргийг хэлэлцэж тохироод гэрээ бичиг тогтчихсон учраас тэд нар Цахарын нутагт “Данжуур”-ыг авч явах зорилгоор шууд хүрч ирсэн байна. Тэрчлэн бас Жамъян гүн нарын Монгол улсын Судар бичгийн хүрээлэнд бичсэн захидлаас үзэхэд Бээжинд Наянт вантай уулзахдаа Монголоос гарч ирэхээсээ өмнө хэлэлцэж тогтсон ёсоор “талархах зүйл”-ийг бэлэглэсэн байна. Ингэж бодвол Жамъян гүн нар нэгдүгээр удаа Бээжинд судар номын эрлээр ирж хагас жил гаруй сууж байхдаа уг хэргийг Наянт вантай хэлэлцэж тогтсон байжээ.

¹⁷ Т.Дашцэдэн. Монгол таталган бичиг. Уб., 2012, х. 303. Уг номын дагалдуулалд буй гэрэл зураг. Зургийн тайлбар нь: Э.Хүрэлбаатар эмхэтгэж 1992 онд хэвлүүлсэн ‘Монгол бичгийн өвөөс’ хэмээх ном ба хувийн архиваас ашиглав. С.Жамъянгийн гарын бичиг (1864-1930). Судар бичгийн хүрээлэнгийн захирал асан, жанжин Сүхбаатарын номын багш, их бичгийн хүн гэж бий).

¹⁸ Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд буй “Данжуур”-ыг залсан хөшөө чулууны бичиг. Энд уг гэрээ бичгийг олж үзсэнгүй болохоор хөшөө чулуун дахь сийлбэрийн агуулгыг ашиглав. Хөшөөний нүүр талын 8-р мөр.

4. Тэмээнд ачиж явсан Наянт вангийн “Данжуур”

“Замын тэмдэглэл”-ийн агуулгыг залган үзвэл, Бээжинд томилж явуулсан Хишигдалай “3 сарын шинийн 2-нд эгэж ирэв”¹⁹ хэмээх тэмдэглэл буй. Тухайлбал Хишигдалай бүхэл 20 хоногийн дараа буцаж ирсэн байна.

3 сарын 11-ний өдрийн “Замын тэмдэглэл”-д “хуучин сүмийн газар Хишигдалайн хамт очиж монгол Данжуурын 226 боть номыг бүртгэн хүлээж аваад 15 үхэр тэргэнд чуулж сууж буй айлд 15-нд хүргэж ирэв”²⁰ хэмээн тэмдэглэжээ. Үүнээс юуны өмнө “Данжуур”-ыг “хуучин сүм”-д хадгалж байсан гэдгийг мэдэж болно. “Хуучин сүм”-ийг “Данжуур”-ыг залсан “гэрээ бичиг”-т “Шашныг бадруулагч сүм” хэмээн тэмдэглэж буй. “Шашныг бадруулагч сүм”-ийн нөгөө нэрийг “Шаргын сүм” гэдэг. Одоогийн Шилийнгол аймгийн Шулуун хөвөөт цагаан хошууны Шарга нуур бригадын Шарга нуур багт харьяалагдана. Уулын Цахар найман хошууны Хөвөөт цагаан хошууны зургадугаар сум “Өөлд”-ийн нутгийн харьяанд байжээ. “Шашныг бадруулагч сүм” гэдэг нь Чин улсын засгийн газраас өгсөн өргөмжлөлийн нэр болох юм. Ардын дунд “Шаргын сүм” хэмээн нэрлэдэг. Агваанлавсүм нарын найруулсан “Шилийн голын сүм хийд” хэмээх номд “Шаргын сүмийг бас Шашныг бадруулагч сүм гэдэг. Энэ сүм гурван хүрээтэй жижигхэн сүм байв”²¹ гэх зэргээр тэмдэглэсэн байдаг. Дараа нь 11-ний өдөр Хишигдалайн хамт очоод 15-ны өдөр тээж ирсэн гэдгээс үзвэл энэхүү хуучин сүмд дөрвөн өдрийн цаг хэрсэн “Данжуур”-ыг бүртгэн дуусаж Жамъян гүн нарын буусан айлд хүрч ирсэн гэснийг мэдэж болно.

11-ний өдрөөс 18 болтолх өдрийн тэмдэглэлгүй, 19-ний өдрийн тэмдэглэлд “Судар номын зэрэг зүйлийг тэмээнд ачиж Хүрээ зүг зорьж гараад Цахар Хөвөөт шар хошууны нутаг Хонгор овооны зүүн сугад хоноглов”²² гэж буй. 11-ний өдрөөс 19-ний өдрийн хоорондох долоон өдөрт “Данжуур”-ыг авч явах бэлтгэл ажлыг хийсэн бололтой. Тэрчлэн “Данжуур” судрыг тэмээнд ачиж явсан байна. Монгол улсын Үндэсний номын санд “Монгол ‘Данжуур’-ыг залж ирэхтэй холбогдсон баримт” хэмээх нэр бүхий Жамъян гүн нар тэмээнд ачих хэрэгсэл худалдаж авсан бас нэг хувь данс бичиг буй. Түүний агуулгыг сийрүүлбэл доорх мэт:

Монгол Данжуур 226 боть хэмээмүй. Хэмжээ нь: урт нь 2 чи 3 цүн, өргөн нь 2 цүн 5 пүн. Нэг ботийн хүнд нь бараг 20/25/30 жингийн төсөвтэйгөөр бодохуйд нэг тэмээнд гурван зуугаад жин ачихаар бодоход хирцүүлэн 38 авдар хийлгээж, авдар бүрд их хэмжээтэй маажинтай цюнбүү 38, ороох даавуу 93, бүдүүн нарийн олс 38-г бэлтгэвэй.

Үүнд авдрыг бусад хэрэглэлийн хамт авбай.

*Жамъянгийн гарын тэмдэг (тамга)*²³

Энэ дансанд өдөр сарыг тэмдэглэсэнгүй боловч Жамъян гүнгийн гарын үсэгтэй бөгөөд 226 боть “Данжуур”-ыг ачиж авч явах үйл хэрэгтэй холбогдож байгаа болохоор зайлшгүй Наянт вангийн “Данжуур”-ыг авч явах үеийн данс тэмдэглэл болно. Энэ нь өмнө хэсэгт ишилсэн Жамъян гүн нарын Монгол улсын Судар бичгийн хүрээлэнд бичсэн захидалд “Бэжин (Бээжин)-гээс гараад Жанчхүү дайран авдар юмыг тээлгэн Данжуур залж буй сүмийн газар очиж...”²⁴ хэмээх агуулгатай яг сайхан нийцэж буй. Өөрөөр хэлбэл, Жамъян

¹⁹ “Судар бичгийн хүрээлэнгийн дарга сайд Жамъянгийн бие Хятад улсын Бээжин хотноо жич Эрдэнэзуугийн зэрэг газар очиход тэмдэглэсэн замын тэмдэглэлийн хамт”, Монгол улсын Үндэсний номын сангийн хадгаламж (хадгаламжийн дугаар: 2220/96), х.54.

²⁰ Мөн тэнд, х.54.

²¹ Агваанлавсүм нар, *Шилийн голын сүм хийд*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 2014, х.204-205.

²² Мөн тэнд, х.54

²³ Монгол ‘Данжуур’-ыг залж ирэхтэй холбогдсон баримт. Монгол улсын Үндэсний номын сангийн хадгаламж (Хадгаламжийн дугаар: 18521/97).

²⁴ Т.Дашцэдэн. Монгол таталган бичиг. Уб., 2012, х. 303. Уг номын дагалдуулалд буй гэрэл зураг. Зургийн тайлбар нь: Э.Хүрэлбаатар эмхэтгэж 1992 онд хэвлүүлсэн ‘Монгол бичгийн өвөөс’ хэмээх ном ба хувийн архиваас ашиглав. С.Жамъянгийн гарын бичиг (1864-1930). Судар бичгийн хүрээлэнгийн захирал асан, жанжин

гүн нар эдгээр багаж хэрэгслийг худалдаж авсан газар нь Жанчхүү болох бөгөөд цагийн хувьд Олноо өргөгдсөний 15 оны цагаан сарын 27-ны өдрөөс мөн оны 2 сарын шинийн 3-ны хооронд байх ёстой. Учир нь Жамъян гүн нар Бээжингээс Цагаан сарын 26-ны орой Жанжякоу зүг мордож, тэнд 5 хоноод 2 сарын 3-ны өдөр морин тэргэнд сууж Жанчхүүгээс Цахарын нутаг зүг аялсан тухай “Замын тэмдэглэл”-д тодорхой тэмдэглэж²⁵ буй. Тухайлбал, Жамъян гүн нар Жанчхүүгээс худалдаж авсан тэдгээр тэмээнд ачих хэрэгслүүдийг морин тэргэнд тээж Наянт вангийн хуучин сүм зүг авч явсан байжээ.

“Замын тэмдэглэл”-д үндэслэвэл, Жамъян гүн нар 3 сарын 19-ний өдөр Наянт вангийн “Данжуур”-ыг тэмээнд ачиж яваад, 4 сарын 12-ны өдөр Хүрээнд хүрсэн²⁶ гэж тэмдэглэж буй. Үүнээс үзвэл Жамъян гүн нар тэмээгээр сар шахмын хугацаа явж Их Хүрээнд “Данжуур” номыг залж аваачсан байна.

5. “Данжуур” номыг Ар Монголд шилжүүлсэн Наянт вангийн зорилго

Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд “Данжуур”-ыг залсан тухай хөшөө чулууны бичиг буйг эрдэмтэд сайн мэддэг. Тус хөшөө чулууны бичиг бол өгүүлэн буй “Данжуур” номыг залахад Наянт вантай тогтсон гэрээ бичгийн хуулбар болно. Тэрхүү гэрээ бичгийн агуулгыг ерөнхийд нь үзвэл, Наянт ван дээдийн үеэсээ тахисаар ирсэн үнэт нандин зүйл болох “Данжуур” номыг Ар Монголд залж аваачсаны дараа хэрхэн хамгаалах асуудалд ихэд санааширч байсан агуулга зонхилно.

“Гэрээ бичиг”-т тогтсон есөн зурвас агуулгыг сийрүүлбэл доорх мэт:

Нэгдүгээр зүйл. Энэ Данжур (Данжуур) ном болбоос Сэцэн чин ван Наянтын дээдэс өвгөдөөс тахисаар үлдсэн ирсэн судар ном болой. Өдгөө Эрдэнэ жонон жүн ван Ширнэндамдин нар Бээжин (Бээжин)-д ирж залж аваачмуй хэмээсэнд Сэцэн чин дуртайяа энэ Данжуур номыг Их Хүрээнд хүргэн тахиулж үнэ хэрэгсэл хэмээн ч авахгүй, гагц үүнийг басхүү Сэцэн чин вангийн буй бүхий ном судар хэмээмуй.

Хоёрдугаар зүйл. Энэ Данжур (Данжуур) ном болбоос бүрнээ нийт хоёр зуун хорин зургаан ботийг дагалт Хишигдалай бүрнээ жонон ван нар дутагдалгүй тушаан өгвэй.

Гуравдугаар зүйл. Энэ Данжур (Данжуур) номыг үүрд Их Хүрээ Ардыг Гэгээрүүлэх Яамны Судар бичгийн хүрээлэнд хичээнгүйлэн хураан тахиж, огт бусад хүний дураар салган зээлж гадагш гаргаж үзэхээр бас бус газарт нүүлгэн хурааж үл болмуй.

Дөрөвдүгээр зүйл. Энэ Данжур (Данжуур) номыг хожмын өдөр хэрвээ бус хүн гаран ирж дахин хэвлэн дарж авмуй хэмээх учир гарваас эрхгүй Сэцэн чин вангийн фүд мэдэгдэж зөвлөн тогтоосон хойно сая үйлдэж болмуй

Тавдугаар зүйл. Энэ Данжур (Данжуур) номыг хожмын өдөр хэрвээ муу хүн гарч гуйчаар худалдаа ба далдуураар бус хүнд зээлэн өгч хураалгах хэрэг учир гарах болбоос Сэцэн чин вангаас байцаан мэдсэн хирд даруй албан яамнаа мэдүүлж цааз хуулиар ял шийтгүүлэхээс гадна бас тоо ёсоор төлүүлэн авмуй.

Зургадугаар зүйл. Энэ Данжур (Данжуур) номыг хожмын өдөр хэрвээ сүйтгээж эвдрээд бүрэн гүйцэдгүй болох болбоос тэр цагт даруй мөн хурааж байсан газрын хүн нараас засамжлан нөхүүлж гүйцэтгэх хэрэгтэй.

Долдугаар зүйл. Энэхүү номыг Судар бичгийн хүрээлэнд үүрд эрдэнэчлэн хадгалах тул энэ гэрээ бичгийг хөшөө чулуун дээр сийлж тавимуй.

Наймдугаар зүйл. Урьдах зүйл бүхнийг хоёр этгээдээс нүүр золголцож хэлэлцэн тогтсон тул үүрд яваад [хэн] ч зөрчиж үл болмуй.

Сүхбаатарын номын багш, их бичгийн хүн гэж бий).

²⁵ Мөн тэнд. х.52

²⁶ Мөн тэнд. х.56

Есдүгээр зүйл. Энэ гэрээ бичгийг монгол, нангиад хоёр зүйлийн үсгээр хавсран дөрвөн хувь бичиж Сэцэн чин вангийн фүд нэгэн хувь, Жонон жүн ванд нэгэн хувь, Сэцэн чин вангийн Тамгийн газар нэг хувь, Хүрээний Ардыг гэгээрүүлэх яамны Судар бичгийн хүрээлэнд нэг хувь тус тус хадгалж цөмийг хянан байцаажухуй.

Монгол улсын арван дөрөвдүгээр он арван сарын хорин найман Наянт Ширнэндамдин Жамъян²⁷

Дээрх есөн зурвас агуулгаас тодорхойлж болох нь 1. Тус “Данжуур” ном бол Наянт вангийн дээдэс өвгөдөөс тахисаар ирсэн судар ном болно. 2. Наянт ван тус “Данжуур” номыг Судар бичгийн хүрээлэнд худалдаж өгөх биш, зөвхөн Их Хүрээнд аваачиж хадгалах буюу тахиж болно. Тэрчлэн уг номыг ер нь Наянт вангийн өмч хэмээн мэдэх хэрэгтэй. 3. 2-8 дугаар зурвасын тогтоолыг үзвэл, юуны өмнө “Данжуур” номыг бүрэн бүтнээр тушааж өгснийг тодорхойлсон бөгөөд дараа нь “Данжуур”-ыг Их Хүрээнд аваачсаны дараа гадагш зээлүүлэх, хэвлэж дарамлах, худалдаа, эвдэрч сүйдэх зэргээс их л болгоомжилсон агуулга голлож байна. Эцэст энэ гэрээг чулуун дээр сийлэх ба монгол, нангиад хоёр хэлээр дөрвөн хувь бичиж дөрвөн зүйлийн газар хадгалах тухай сүүлийн зурвасыг тогтоосон нь уг гэрээг улам хүчин төгөлдөр болгох гэсэн санаа болох нь тодорхой байна.

Бодуштай зүйл гэвэл, Наянт ван “Данжуур” номыг гадагш зээлүүлэх, хэвлэж дармаллах, худалдаа, эвдэрч сүйдэх зэргээс их л болгоомжилж байсан бөгөөд бас “Гагц үүнийг басхүү Сэцэн чин вангийн буй бүхий ном судар хэмээмүй” (мөн л Наянт вангийн ном судар гэж үзэх хэрэгтэй гэсэн үг) хэмээн уг номын төлөө маш их санаа зовж байтлаа юунд бас зээлүүлж өгөх вэ гэдэг асуудал болно. Тэрчлэн энэхүү “Данжуур” ном бол Наянт вангийн дээдсийн үеэс тахисаар ирсэн уламжлалтай байтлаа “дуртайяа энэ Данжуур номыг их хүрээнээ хүргэн тахиулах” зэрэг гэр дэх агуулгууд нь хоорондоо зөрчилтэй мэт. Бодвол, дээр зууны хориод оны үеийн цаг төрийн үймээнд Наянт ван “Данжуур” номыг амар төвшин авч үлдэх боломж багатай байсан учраас Монгол улсын Судар бичгийн хүрээлэнд шилжүүлж хадгалах гэсэн санаа бололтой.

Өгүүлсэн бүхнийг хураангуйлбал, Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа Судар бичгийн хүрээлэнгийн сайд Жамъян гүн нарын Бээжин хотноо зорчсон “Замын тэмдэглэл” ба холбогдол бүхий архивын данснууд, жич хөшөө чулуунд сийлсэн гэрээ бичиг зэрэг олон талын баримтуудад суурилж, Наянт вангийн “Данжуур”-ыг Ар Монголд залсан түүхэн үйл явдал тодорхой болгосон байна. Тухайлбал, Жамъян гүн нар хоёрдугаар удаа ном судрын эрлээр Бээжинд ирээд Олноо өргөгдсөний 15 дугаар оны цагаан сарын үеэр Наянт вантай уулзан түүний дээдийн үеэс тахиж ирсэн “Данжуур” номыг Ар Монголд залж аваачих тухай хэлэлцэж гэрээ бичиг тогтсон байна. Дараа нь Жамъян гүн нар Бээжингээс мордож Жанчхүүгээр дайран “Данжуур” номыг тэмээнд ачиж явахад хэрэглэх авдар болон олсон дээс зэрэг хэрэгслийг худалдан авчээ. 4 хоногийн дараа Жанчхүүгээс морин тэргээр мордож 2 сарын 6-ны өдөр Наянт вангийн Цахар дахь ордонд хүрсэн байна. 2 сарын 12-ны өдөр “Данжуур”-ыг авч явахад саад учирсан болохоор Хишигдалай хэмээгч Наянт вангийн түшмэлийг Бээжинд дахин явуулжээ. 20 хоногийн дараа буюу 3 сарын 2-ны өдөр Хишигдалай Бээжингээс буцаж ирсний дараа Жамъян гүн нар “Данжуур” номыг тахиж байсан Шашныг бадруулагч сүмээс уг номыг бүртгэн тоолж аваад, Жанчхүүгээс бэлтгэж авчирсан авдарт багцалж тэмээнд ачаад 2 сарын 19-ний өдөр Наянт вангийн харьяат нутгаас Хүрээ зүг мордсон байна. Тус жилийн 4 сарын 12-ны өдөр тэд нар хүрээд хүрч энэ удаагийн аялал дуусжээ. Наянт ван дээдийн үеэсээ тахисаар ирсэн “Данжуур” номыг нандигнан тахиж байсан боловч цаг төрийн үймээнд үрэгдэн сүйдэхээс болгоомжлон Монгол улсын Судар бичгийн хүрээлэнд шилжүүлж цаг төрийн үймээнээс зайлуулсан нь тэр юм.

²⁷ Монгол улсын Үндэсний номын сангийн гол танхимд байгаа “Данжуур”-ыг залсан хөшөө чулууны бичиг. Энд уг гэрээ бичгийг олж үзсэнгүй болохоор хөшөө чулуун дахь сийлбэрийн агуулгыг ашиглав. Хөшөөний нүүр талын 6 дугаар мөрөөс хөшөөний ар талын агуулга төгсөх хүртэл.